

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2015 оны 5 дугаар сарын 01-ний өдөр

Гэрээний нэр, дугаар: АХО-2015-1

Төслийн нэр, дугаар: “Бор-Өндөрийн УБҮ-ийн ажиллагсдад нийтийн хоолны үйлчилгээ үзүүлэх”

“Монголросцветмет” ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдыг “Бор Өндөр УБҮ-ийн ажиллагсдад нийтийн хоолны үйлчилгээ үзүүлэх” тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **50000** төгрөгөөр худалдан авч болно.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

- **Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилд хийж гүйцэтгэсэн ажлын аль нэг жилийн борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
- **Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх
- **Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 2 жил
- **Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Сүүлийн 3 жилийн аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй үйлчилгээг гүйцэтгэсэн байх. /Нотлох баримт болгож гэрээ болон гэрээ дүгнэсэн актын хуулбарыг хавсаргаж ирүүлнэ./

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба тендерийн үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх дүнтэй тендерийн баталгаатай хамт ирүүлнэ.

Тендерийг 2015 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 14:00 цагаас өмнө “Монголросцветмет” ХХК-ийн тендерийн комисст” гэж хаяглан Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Энхтайваны гудамж 98, Монголросцветмет ХХК-ийн байр, өрөө 402 тоот хаягаар ирүүлэх бөгөөд тендерийг 2015 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 14:30 цагт тус компанийн 2 давхар дахь уулзалтын танхимд уг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан нээнэ.

Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Давуу эрх олгохгүй.

**Хаяг: Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 98,
“Монголросцветмет” ХХК-ийн байр, 402 тоот өрөө,
утас: 450060-112, факс: 458380 шуудангийн хаяг: Улаанбаатар 51, ш/х- 002**

МОНГОЛРОСЦВЕТМЕТ ХХК